



МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ  
НЭГДЭЛ" ХК-ИЙН ЗАХИРАЛ  
М.ОТГОНБААТАР ТАНАА

## "БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
2-р хороо, "Урбанек" ХХК-ийн  
байранд 307 тоот  
Утас: 324338, 98056465,  
89116465, 98006465  
И-мэйл: fortune\_audit@yahoo.com

2021. 08. 04 № 28

таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Г

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

#### **Зөрчилгүй дүгнэлт**

Бид “Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн 2020 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон Орлогын дэлгэрэнгүй, Өмчийн өөрчлөлт, Мөнгөн гүйлгээний тайлангууд болон эдгээр тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон Нягтлан бodoх бүртгэлийн бодлогуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Монгол улсын Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаалаар батлагдсан нягтлан бodoх бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Аудитын явцад нягтлан бodoх бүртгэлийн хувьд баримталсан зарчим, сонгож хэрэглэсэн арга, дотоод хяналтын системийг судлав. Санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэл бүхий нотолгоо олж авах зорилгоор аудитын түүврийн болон бусад арга горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.

#### **Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаа зөрчилгүй бэлтгэж, нягтлан бodoх бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, шударгаар толилуулахтай холбоотой, зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын

талаарх хариуцлагыг хүлээнэ. Засаглал хариуцсан этгээдүүд санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

#### **Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний зорилго бол ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэгдсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

ЗАХИРАЛ



Ж. ОЮУНЦЭЦЭГ